

**“ХОЛБООНЫ ТӨМӨР БЕТОН УГСАРМАЛ ХУДАГ MNS 3966:1987” СТАНДАРТЫГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

|  |   |
|--|---|
| <p>Боловсруулах үндэслэл, хэрэгцээ, шаардлага</p>  | <p>Уг стандарт нь 1987 онд батлагдсан бөгөөд холбооны төмөр бетон угсармал худгийн худгийг үйлдвэрлэх, шалгаж хүлээж авах, хадгалах, тээвэрлэхэд хамаарах үзүүлэлтүүд болох үндсэн хэмжээ, хэлбэр, техникийн шаардлагуудыг тогтоосон.</p> <p>Гэвч уг стандартад худгийн хийц, бүтээцийн шаардлагыг тогтоогоогүйн улмаас чанарын шаардлага хангаагүй худгууд ихээр ашиглагдаж байгаа ба үүнээс үүдэн худаг сувагчлал гэмтэх, кабель шугам тасрах, тоос шороо, борооны ус, хүчтэй салхи гэх мэт байгалийн үзэгдлийн нөлөө, хүний хүчин зүйлээс шалтгаалах механик гэмтэлд өртөх магадлал ихсэх, цаашилбал харилцаа холбооны үйлчилгээний чанар доголдох эрсдэл үүсгэж байна.</p> <p>Иймд холбооны худгийн хийц бүтээцийн тооцоог стандартад заасан гаднын хүчин зүйлээс хамаарах ачаалал, нормын дагуу боловсруулж, дагалдах тоног хэрэгсэлд тавигдах шаардлагуудыг холбогдох норм дүрэмтэй уялдуулан тодорхойлж уг стандартад тусгах шаардлагатай байна.</p> |
| <p>Стандартын хамрах хүрээ /стандартаар юуг тодорхойлох, зайлшгүй тусгах, шинэчлэх шаардлагууд/</p>                | <p>Худгийн арматур, бетон зуурмагийн үзүүлэлтүүд, тавигдах шаардлагууд /орчин, нөхцлөөс нь хамааруулан/</p>   |
| <p>Стандартыг хаана мөрдөх</p>   | <p>Холбооны төмөр бетон угсармал худгийг үйлдвэрлэх, угсарч суурилуулах, ашиглалт, үйлчилгээ явуулах, шалгаж хүлээж авах, хадгалах, тээвэрлэх хяналт тавихад хамаарна.</p>  |
| <p>Стандарттай уялдуулах хууль тогтоомж, үндэсний болон олон улсын стандартууд, бусад холбогдох баримт бичгүүд</p> | <p>Олон улсын болон үндэсний стандарт, барилгын бүтээцийн норм дүрэм, зөвлөмжүүд, бусад холбогдох хууль, дүрэм журам, баримт бичгүүд, тэдгээрт тусгасан нэр томъёо, тодорхойлолтууд</p> <p>Барилгын бүтээцийн норм дүрмүүд, харилцаа холбоо, болон барилгын олон улс, үндэсний стандарт, норм дүрэм, зөвлөмжүүд, бусад холбогдох хууль, дүрэм журам, баримт бичгүүд, тэдгээрт тусгасан нэр томъёо, тодорхойлолтууд</p>  |